



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 4/539

Мандатговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын 2018 оны А/243 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих "Эрдэнэдалай сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын засвар"-ийн ажлын гүйцэтгэгчээр "Түмэнзасал" ХХК-ийг сонгон 31,570,763 (Гучин нэгэн сая таван зуун далан мянга долоон зуун жаран гурав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг чанартай гүйцэтгэн хүлээлгэж өгөхийг "Түмэнзасал" ХХК-ний захирал (Ш.Баярдалай)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Эрдэнэдалай сумын Засаг дарга (С.Мөнхбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж. МӨНХЧУЛУУН

480010034